



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠶᠢᠨ
ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ
ᠪᠠᠶᠳᠠᠯ


БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2025 2 сар










www.ubstat.mn

[www.facebook.com/Багануур дүүргийн Статистикийн хэлтэс](https://www.facebook.com/Багануур-дүүргийн-Статистикийн-хэлтэс)

www.1212.mn



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2021-2025 ОН	3
 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
 ЭРҮҮЛ МЭНД	7
 ГЭМТ ХЭРЭГ	9
 ҮНЭ ХАНШ	13
 АЖ ҮЙЛДВЭР	16
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	18

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, 2024 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	162 098	36 472	5 987	32 925	52 115	34 599
Үүнээс:						
Тэмээ	49	10	7	30	-	2
Адуу	19 099	4 959	781	4 339	4 574	4 446
Үхэр	20 434	5 449	1 330	4 123	5 376	4 156
Хонь	71 973	15 457	2 329	14 434	25 547	14 206
Ямаа	50 543	10 597	1 540	9 999	16 618	11 789

ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 I-II	2022 I-II	2023 I-II	2024 I-II	2025 I-II
Суурин хүн ам	тоо	29 433	29 341	28926		
Төрөлт	тоо	41	42	55	52	52
Нас баралт	тоо	9	16	9	10	25
Шилжиж ирсэн	тоо	52	50	86	92	91
Цэвэр өсөлт	хувь	0.11	0.08	0.15	0.15'	0.09'

'өмнөх оны суурин хүн амаас тооцов.

ЗУРАГ 1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, 2024 ОН






БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2025 оны 2 дугаар сарын эцэст 159 иргэн идэвхтэй ажил хайж бүртгүүлсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 101 (2.7 дахин) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, 2 дугаар сард, тоогоор




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 31 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 16 (51.6%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ШАЛТГААНААР, 2 дугаар сард, тоогоор



Мөн энэ хугацаанд 7 иргэн ажилд зуучлуулан орсноос хувьцаат компанид 2, төсөвт байгууллагад 1, бусад байгууллагад 4 иргэн тус тус ажилд оржээ.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, тоо, хувиар



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 30 (18.9%) нь 15-24 насны, 50 (31.5%) нь 25-34 насны залуучууд, 36 (22.6%) нь 35-44 насныхан, 42 (26.4%) нь 45-с дээш насныхан, 1 буюу (0.6%) нь 60+ насныхан эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролоор, 2 дугаар сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2024 II	2025 II	2024 II	2025 II
	тоогоор			
Ажилгүйчүүд, бүгд	58	159	27	79
Үүнээс:				
Дээд боловсролтой	18	51	13	39
Тусгай дунд боловсролтой	5	4	2	2
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	5	12	1	3
Ерөнхий боловсролтой	30	87	11	34
Бага болон боловсролгүй	-	5	-	1

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 51 (32.1%) нь дээд боловсролтой, 4 (2.5%) нь тусгай дунд боловсролтой, 12 (7.5%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 87 (54.8%) нь ерөнхий боловсролтой, 5 (3.1%) нь бага болон боловсролгүй иргэд ажээ. Ажил хайгч иргэдийн 79 (49.7%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 4.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.5 (35.9%) тэрбум төгрөгөөр буурсан бол зарлага 11.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.9 (35.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 3.6 (79.4%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 369.6 (8.3%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 417.5 (9.3%) сая төгрөг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний сангаас, 134.9 (3.0%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар



ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний II сард

Үзүүлэлт	2024	2025	Өсөлт бууралт	
	I-II	I-II	тоо	хувь
	сая төгрөг			
Сангийн орлого, бүгд	6 984.0	4 477.6	-2 506.4	- 35.9
тэтгэврийн сан	5 539.0	3 555.6	-1 983.4	- 35.8
тэтгэмжийн сан	586.0	369.6	- 216.4	- 36.9
ажилгүйдлийн сан	739.0	417.5	- 321.5	- 43.5
ҮОМШӨ ¹ -ний сан	120.0	134.9	14.9	12.4
Сангийн зарлага, бүгд	8 153.0	11 060.9	2 907.9	35.7
тэтгэврийн сан	7 464.0	9 947.8	2 483.8	33.3
тэтгэмжийн сан	233.0	434.0	201.0	86.3
ҮОМШӨ ¹ -ний сан	318.7	358.3	39.6	12.4
Ажилгүйдлийн сан	137.3	320.8	183.5	133.6

ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, сая төгрөг



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 5232 хүнд 10.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 298 хүнд 434.0 сая төгрөгийн тэтгэмж, 21 хүнд 358.3 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 54 хүнд 320.8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах талаар тусгасан. Үүний хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг бүхэлд нь цахимжуулж дүүрэгт санхүүжилт хуваарилалт хийгдэхгүй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нэг данснаас зарцуулалт хийгдэж байна.

¹ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, эхний II сард

Үзүүлэлт	2024		2025		<u>2025.II</u>	<u>2025.I-II</u>
	II	I-II	II	I-II	2024.II	2024.I-II
	сая төгрөг				хувь	
Сангийн зарлага	1 422.2	3 263.7	2 216.6	3 691.1	155.9	113.1
Тэтгэвэр	145.8	291.8	184.4	367.7	126.5	126.0
Тэтгэмж	102.5	198.3	122.8	240.1	119.8	121.1
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	35.5	68.7	43.6	86.6	122.8	126.1
"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	-	109.4	214.0	214.0	-	195.6
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	0.2	171.1	355.0	355.0	1775.0*	2.1*
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	6.2	11.7	5.9	11.4	95.2	97.4
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1 061.1	2 121.6	1 070.7	2 135.7	100.9	100.7
0-3 хүртэлх настны хүүхэд асаргааны тэтгэмж	50.6	101.6	44.9	89.3	88.7	87.9
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	3.5	21.8	5.3	9.4	151.4	43.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн хөнгөлөлт	1.3	2.5	0.9	2.3	69.2	92.0
"Хүнс тэжээл" хөтөлбөр	12.8	25.6	23.9	23.9	186.7	93.4
Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж	-	0.2	0.2	0.3	-	150.0
Оршуулгын тэтгэмж	-	-	-	6.0	-	-
Ихэр хүүхдийн тэтгэмж	2.0	2.0	-	2.0	0.0	100.0
Онцгой тохиолдлын тэтгэмж	-	-	-	2.4	-	-
Насны хишиг	0.7	137.4	145.0	145.0	207.1*	105.5

*-дахин их

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 474 хүнд 367.7 сая төгрөгийн тэтгэвэр, 406 хүнд 240.1 сая төгрөгийн тэтгэмж, 132 хүнд 86.6 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 144 жирэмсэн эхэд 11.4 сая төгрөгийн тэтгэмж, 10650 хүүхдэд 2.1 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асардаг 905 эцэг, эхэд 89.3 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.


Мөн 30 ахмад настанг 9.4 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламжинд, 986 өрхийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 23.9 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 90 иргэдэд 2.3 сая төгрөгийн хөнгөлөлт, 3 иргэнд 6.0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж, 2 иргэнд онцгой тохиолдлын тэтгэмж 2.4 сая төгрөг, 1856 хүнд 144.9 сая төгрөгийн насны хишиг, өрх толгойлсон 1 эх, эцэгт 0.3 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгожээ.



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 2 сарын байдлаар 64 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 10 (13.5%) буурсан байна. Энэ хугацаанд 43.0 мянган хүн эмнэлгийн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 7.2 (20.2%) мянган хүнээр, хэвтэн эмчлүүлсэн 1.6 мянган хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 39 (2.5%) хүнээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 7. ЭМНЭЛГИЙН НИЙТ ҮЗЛЭГ, эхний II сард




ХҮСНЭГТ 6. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний II сард

Үзүүлэлт	2024 I-II	2025 I-II	$\frac{2025.I-II}{2024.I-II}$
Амаржсан эхийн тоо	75	64	-14.7
Үүнээс бусад аймгийн харьяат	33	26	-21.2
Амьд төрсөн хүүхэд	74	64	-13.5
Үүнээс бусад аймгийн харьяат	32	26	-18.7
Эхийн эндэгдэл	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	2	0	0.0

2025 оны эхний 2 сарын байдлаар бэлгийн замын халдварт өвчний 19 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 52.8%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 4 (17.4%) тохиолдлоор, цочмог халдварт өвчний 17 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 47.2%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 5 (22.7%) тохиолдлоор тус тус буурсан байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 12.4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.1 продицимиллээр буурсан байна.

ЗУРАГ 8. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний II сард


Үзүүлэлт	2024 I-II	2025 I-II	Өсөлт бууралт	
			тоо	хувь
Нийт халдварт өвчин	45	36	-9	-20.0
Бэлгийн замын халдварт өвчин	23	19	-4	-17.4
Заг хүйтэн	14	7	-7	-50.0
Тэмбүү	4	8	4	100.0
Трихомониаз	2	2	-	0.0
Кандилом	1	-	-1	-100.0
Хомхой	1	2	1	100.0
Хламид	1	-	-1	-100.0
Цочмог халдварт өвчин	22	17	-5	-22.7
Цусан суулга	6	1	-5	-83.3
Гипатит	-	1	1	-
Салхин цэцэг	11	12	1	9.1
Рож	1	-	-1	-100.0
Гар хөл амны өвчин	-	1	1	-
Сүрьеэ	4	2	-2	-50.0



ГЭМТ ХЭРЭГ

2025 оны эхний 2 сард дүүргийн хэмжээнд 105 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 43 (69.4%) хэргээр өссөн бол, гэмт хэргийн илрүүлэлт 29.3 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.6 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар




ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, эхний II сард

Хэргийн төрөл	2024 I-II	2025 I-II	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	62	105	43	69.4	100.0
Хүнийг алах	1	-	-1	-100.0	-
Хүний амь нас хохирсон	-	3	3	-	2.9
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	24	37	13	54.2	35.2
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	1	2	1	100.0	1.9
Бусдын эд хөрөнгө хулгайлах	8	11	3	37.5	10.4
Залилан мэхлэх	15	24	9	60.0	22.8
Дээрэмдэх	-	1	1	-	1.0
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	5	7	2	40.0	6.6
Цахим мэдээлэлд хууль бусаар халдах	1	1	-	-	1.0
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	1	2	1	100.0	1.9
Хууль бусаар мод бэлтгэх	-	1	1	-	1.0
Мөнгөн тэмдэгт үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах	2	1	-1	-50.0	1.0
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	1	-	-1	-100.0	-
Автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах	1	1	-	-	1.0
Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	2	14	12	7.0'	13.3
Хэрэг илрүүлэлтийн хувь	30.9	29.3			


' - дахин их

Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнхийг буюу 37 (35.2%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 24 (22.8%) нь залилан мэхлэх, 14 (13.3%) нь автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн хэргүүд тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэг 11 (10.4%), хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших хэрэг 7 (6.6%), хүний амь нас хохирсон хэрэг 3 (2.9%), хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг эсрэг, бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх хэргүүд тус бүр 2 (3.8%), дээрэмдэх, хууль бусаар мод бэлтгэх, цахим мэдээлэлд хууль бусаар халдах, мөнгөн тэмдэгт үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах, автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах хэргүүд тус бүр 1 (5.0%) бүртгэгдсэн байна.


ЗУРАГ 10. СОГТУУГААР БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, эхний II сард



ЗУРАГ 12. ГУДАМЖ ТАЛБАЙД БОЛОН СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эхний II сард




ХҮСНЭГТ 9. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮМҮҮС, эхний II сард

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2024 I-II	2025 I-II	тоо	Хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	26	41	15	57.7
Үүнээс: эмэгтэйчүүд	4	6	2	50.0
хүүхэд	-	2	2	-
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	61	96	35	57.4
Үүнээс: нас барсан	1	5	4	5.0'
гэмтсэн	27	42	15	55.6
Эрүүлжигдсэн хүний тоо	89	80	-9	-10.1
Баривчлагдсан хүний тоо	25	14	-11	-44.0
Учирсан хохирол /сая төгрөг/	106.8	308.5	201.7	188.9
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	3.0	51.8	48.8	17.3'

'-дахин их

ЗУРАГ 13. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ИРГЭД, хувиар, эхний сард



2025 оны эхний 2 сард 41 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 6 (14.6%) нь эмэгтэй, 18 хүртлэх насны хүүхэд 2 (4.9%) тус тус бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд 96 иргэн гэмт хэргийн улмаас хохирсны 42 (43.7%) нь гэмтсэн иргэд бөгөөд нас барсан иргэн 5 (5.2%) бүртгэгдсэн байна.

Мөн 80 иргэн согтуугаар зөрчил гарган саатуулагдаж, 14 иргэн баривчлагдсан нь өмнөх оноос согтуугаар зөрчил гарган

саатуулагдсан иргэд 9 (10.1%)-аар, баривчлагдсан иргэд 11 (44.0%) иргэнээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 308.5 сая төгрөгийн хохирол учирсны 51.8 (16.8%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.




ҮНЭ ХАНШ

2025 оны 2 сарын хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


ХҮСНЭГТ 10. ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНИЙН АЖИГЛАЛТ, II сарын дундаж үнэ

Хүнсний бараа		ХИЖИХ НЭГЖ	2.07	2.14	2.21	2.28
"Алтан тариа" гурил	Дээд	кг	3 300	3 300	3 300	3 300
	I зэрэг	кг	3 100	3 100	3 100	3 100
	II зэрэг	кг	2 200	2 200	2 200	2 200
Будаа	цагаан	кг	4 200	4 200	4 200	4 200
	шар	кг	3 500	3 500	3 500	3 500
Хонины мах	ястай	кг	13 000	13 000	13 500	14 000
	цул	кг	14 500	14 500	15 000	16 500
Үхрийн мах	ястай	кг	15 000	16 000	17 000	18 000
	цул	кг	18 500	18 500	19 500	20 000
Адууны мах, ястай		кг	10 000	10 000	10 000	10 000
Ямааны мах		кг	10 500	10 500	10 500	10 500
Элсэн чихэр		кг	4 000	4 000	4 000	4 000
Сүү /задгай/		л	3 500	3 500	3 500	3 500
Тараг /задгай/		л	4 000	4 000	4 000	4 000
Цэцгийн тос, Орос		кг	6 000	6 000	6 000	6 000
Байцаа		кг	2 000	2 000	2 000	2 000
Манжин		кг	4 000	4 000	4 500	4 500
Төмс	монгол	кг	1 000	1 000	1 000	1 000
Лууван	монгол	кг	2 000	2 000	2 000	2 000
Сонгино	хятад	кг	2 500	2 500	2 500	2 500
	монгол	кг	3 500	3 500	3 500	3 500
Сармис, булцуу		ш	650	650	650	650
Огурцы, хятад		кг	6 000	6 000	6 000	6 000
Помидор, хятад /үрлэн/		кг	6 000	6 000	6 000	6 000
Ургамлын тос/ siesta/		ш	12 000	12 000	12 000	12 000
Өндөг		ш	575	575	575	550
Атар талх		ш	2 500	2 500	2 500	2 500

ЗУРАГ 14. “АЛТАН ТАРИА” ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн II сард



ЗУРАГ 15. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн II сард



ХҮСНЭГТ 11. ДУЛААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Ангилал	Хэмжих нэгж	Тариф	
Орон сууцны халаалт	төг/м ²	845	
(Оюутны байр, подвол, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	төг/ГДж	11 150	
Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Халаалтын улиралд	төг/хүн	4 049
	Хүний тоогоор Халаалтын бус улиралд	төг/хүн	5 668
	Усны зарцуулалтаар	төг/м ³	2 089
Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тариф			
40м ² хүртэл талбайтай айл өрх	төг/сар	4 224	
41м ² -аас 80м ² хүртэл талбайтай айл өрх	төг/сар	7 040	
81м ² -аас дээш талбайтай айл өрх	төг/сар	14 080	
Үйлдвэр, аж ахуйн нэгжийн дулааны эрчим хүчний тариф			
Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	төг/м ³	1 487	
	төг/ГЖ	23 767	
Багануур ХК-ийн халаалт	төг/ГЖ	33 234	
Төсвийн байгууллагын халаалт	төг/м ³	1 549	
	төг/ГЖ	29 693	

ХҮСНЭГТ 12. ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1. Айл өрхийн цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	175.0
Сарын нийт хэрэглээний 151-300 кВт.ц	төг/квт.ц	256.0
Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	285.0
Хоёр тарифт тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас ихгүй хэрэглээ		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	182.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	147.0
Сарын нийт хэрэглээний 151-300 кВт.ц		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	225.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	160.0
Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас дээш		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	265.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	160.0
Гурван тарифт тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас ихгүй хэрэглээ		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	170.0
Оройн хэрэглээ /17.00-21.00/	төг/квт.ц	280.0
Шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	113.0
Сарын нийт хэрэглээний 151-300 кВт.ц		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	190.0
Оройн хэрэглээ /17.00-21.00/	төг/квт.ц	290.0
Шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	113.0
Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас дээш		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	220.0
Оройн хэрэглээ /17.00-21.00/	төг/квт.ц	300.0
Шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	113.0
Сарын суурь тариф	төг/сар	3 200
2. Уул уурхай, үүрэн холбооны үйлчилгээнээс бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгааны тариф		
Энгийн тоолууртай	төг/квт.ц	265.0
Гурван тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	265.0
Оройн хэрэглээ /17.00-22.00/	төг/квт.ц	397.0
Шөнийн хэрэглээ /22.00-06.00/	төг/квт.ц	160.0

*2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс мөрдөж буй тариф

ХҮСНЭГТ 13. УСНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)	1 гкал	84 272
		1м³ (тоолууртай)		
	Зун	1 хүн (тоолуургүй)		
		1м³ (тоолууртай)		
Цэвэр ус ²	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0
	1 л (тоолууртай)	1.5		
	Ус түгээх байраар	2.72		
Бохир ус ²	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0
	1 л (тоолууртай)	1.5		
	Ус соруулах	15.0		

ХҮСНЭГТ 14. ТҮЛШ ШАТАХУУНЫ ҮНЭ

Шатахууны нэр төрөл	2021 II	2022 II	2023 II	2024 II	2025 II
	төгрөг				
АИ -76,80	1 450	2 295	2 420	2 420	2 420
АИ -92	1 470	2 270	2 440	2 440	2 440
Дизель түлш	2 180	2 850	3 950	3 990	3 240

2025 оны 2 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-80 болон АИ-92 бензин өмнөх онтой ижил түвшинд, дизель түлш 750 (18.8%) төгрөгөөр буурсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2025 оны эхний 2 сарын байдлаар 60.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 12.8 (27.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


ХҮСНЭГТ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, эхний II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2024 I-II	2025 I-II	<u>2025.I-II</u> 2024.I-II	2024 I-II	2025 I-II	<u>2025.I-II</u> 2024.I-II
Бүгд					47 455.5	60 301.8	127.1
Нүүрс олборлолт	м.тн	1 014.4	1 031.6	101.7	43 933.7	55 800.3	127.0
Дулаан дамжуулалт	м.гкал	55.9	52.9	94.6	3 139.5	3 721.2	118.5
Талх, нарийн боов	тн	40.4	47.6	117.8	202.0	263.6	130.5
Зайлуулсан хог хаягдал	м.м3	9.3	9.6	103.2	180.3	516.7	2.8'


'-дахин их

Тайлант хугацаанд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 17.2 (1.7%) мянган тонноор буюу 11.7 (27.0%) тэрбум төгрөгөөр, талх нарийн боовны үйлдвэрлэлт өнгөрсөн оноос 7.2 (17.8%) тонноор буюу 61.6 (30.5%) сая төгрөгөөр, тайлант хугацаанд 9.6 мянган метр куб хог зайлуулсан нь өмнөх оноос 0.3 (3.2%) мянган метр куб-ээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Харин дулаан үйлдвэрлэлт биет хэмжээгээр 3.0 (5.4%) мянган гкал-аар буурч, үнийн дүнгээр 581.7 (18.5%) сая төгрөгөөр өссөн байна.


ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар



ЗУРАГ 17. ТАЛХ, НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар



ЗУРАГ 18. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, мянган тонн, жил бүрийн эхний II сард






НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 813.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 99.1 (13.9%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 207.5 (25.5%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

ХҮСНЭГТ 16. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ОРЛОГО, эхний II сард

Үзүүлэлт	2024 I-II	2025 I-II	Өсөлт бууралт	
			тоо	хувь
	сая төгрөг			
Нийт орлого	714.6	813.7	99.1	13.9
Орон сууц	202.5	233.5	31.0	15.3
Ус борлуулалт	256.2	277.4	21.2	8.3
Сувагжуулалт	228.7	250.1	21.4	9.4
Бусад	27.2	52.7	25.5	93.8

ЗУРАГ 19. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөг



ХҮСНЭГТ 17. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООДЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний II сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөний биелэлт
	мянган төгрөг		
Нийт дүн	142 515.5	125 800.4	88.3
Тавлаг өргөө	28 509.0	26 114.6	91.6
Маргад өргөө	25 340.2	18 350.5	72.4
Сод хөгжил	26 095.0	22 539.3	86.4
Шинэ элч	27 104.0	23 405.2	86.4
Уурхайчин	19 960.9	18 410.7	92.2
Содон суварга	15 506.4	16 980.1	109.5

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах
ТОГЛООМ



Валютын ханш



аппликейнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn